




НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР



2026 IV

НИЙСЛЭЛИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ





**НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР**

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2021-2025 он	4
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	4
I	Эрүүл мэнд	6
II	Гэмт хэрэг	10
III	Төсөв	13
IV	Хэрэглээний үнэ	17
V	Мал аж, ахуй	22
VI	Аж үйлдвэр	25
VII	Барилга	30
VIII	Хотын нийтийн аж ахуй	34
IX	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	36

ХҮСНЭГТ 1. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 I-IV	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	10 199 ^{↓162}	11 580 ^{↑135}	10 347 ^{↓106}	9 657 ^{↓67}	9 690 ^{↓03}	
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	145 134 ^{↑7.1**}	6 179 ^{↓95.7}	5 972 ^{↓3.4}	7 147 ^{↑19.7}	8 352 ^{↑16.9}	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	9 746 ^{↑20**}	9 678 ^{↓0.7}	9 058 ^{↓6.3}	13 119 ^{↑44.8}	13 818 ^{↓5.3}	
Хэрэглээний үнийн индекс, (жилийн өөрчлөлт)	Хувь	2.9 ^{↓0.5}	1.4 ^{↓1.5}	0.6 ^{↓0.8}	0.3 ^{↓0.3}	3.0 ^{↑2.7}	
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	3 042 ^{↑6.7}	3 496 ^{↑14.9}	3 377 ^{↓3.4}	3 542 ^{↑4.9}	3 574 ^{↑0.9}
	Юань (БНХАУ)	Төгрөг	473 ^{↑8.2}	508 ^{↑7.4}	466 ^{↓8.3}	485 ^{↑4.1}	523 ^{↑7.8}
	Рубль (ОХУ)	Төгрөг	38	43 ^{↑13.2}	36 ^{↓16.3}	43 ^{↑19.4}	47 ^{↑9.3}
Нийслэлийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	423.2 ^{↑25.7}	613.4 ^{↑44.9}	958.3 ^{↑56.2}	1 137.8 ^{↑18.7}	1 243.2 ^{↑9.3}	
Нийслэлийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	354.6 ^{↑7.9}	539.5 ^{↑52.1}	718.4 ^{↑33.2}	1 363.8 ^{↑89.8}	1 606.2 ^{↑17.8}	
Агаарын дундаж температур	°C	3.4	0	4.9	4.7	3.7	

* Дахин их

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 I-IV						2026 I-IV					
		Хотын дундаж	Хамгийн өндөр			Хамгийн бага			Хотын дундаж	Хамгийн өндөр			Хамгийн бага
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	357	Баянгол	8 797	Налайх	59	357	Баянгол	8 797	Налайх	59		
			Чингэлтэй	1 490	Багануур	47		Чингэлтэй	1 490	Багануур	47		
			Сүхбаатар	688	Багахангай	32		Сүхбаатар	688	Багахангай	32		
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	16	Багануур	29	Баянзүрх	10	15	Багануур	37	Хан-Уул	9		
			Сүхбаатар	17	Чингэлтэй	9		Налайх	23	Баянгол	6		
			Налайх	18	Багахангай	-		Сүхбаатар	14	Багахангай	-		
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	43	Багануур	42	Хан-Уул	26	50	Багануур	49	Сүхбаатар	31		
			Баянзүрх	39	Налайх	18		Баянзүрх	48	Налайх	25		
			Баянгол	34	Багахангай	13		Чингэлтэй	38	Багахангай	5		
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	83	Баянзүрх	123	Баянгол	91	77	Баянзүрх	191	Налайх	86		
			Сүхбаатар	121	Багахангай	80		Хан-Уул	175	Багахангай	58		
			Хан-Уул	120	Багануур	26		Чингэлтэй	119	Багануур	25		
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	119	Сүхбаатар	200	Сонгино-хайрхан	78	125	Сүхбаатар	213	Багануур	69		
			Чингэлтэй	140	Налайх	41		Чингэлтэй	175	Багахангай	45		
			Баянгол	133	Баганхангай	29		Баянгол	142	Налайх	40		

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй

* урьдчилсан гүйцэтгэл

** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга =1000

сая=10⁶

тэрүм =10⁹

их аяд =10¹²

мянмянга

% хувь

мммиллиметр

см сантиметр

дм дециметр

м метр

км километр

м² метр квадрат

дм² дециметр квадрат

км² километр квадрат

м³ метр куб

га гектар

мл миллилитр

л литр

г грамм

кг килограмм

цн центнер

т тонн

Вт ватт

кВт.ц киловатт цаг

кал калори

ккал килокалори

Гкал гигакалори(=10⁹ калори)

с секунд

мин минут

мкг/м³ микрограмм метр куб


м/с метр секунд

ш ширхэг

х.д.х

хэвлэлийн даралтат

хуудас



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД

2026 оны эхний 4 сард 9566 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 6(0.1%) төрөлтөөр өссөн байна.

Нийслэлийн хэмжээнд 2026 оны эхний 4 сард 9566 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 6(0.1%) төрөлтөөр өссөн байна. Нийт төрөлтийн 4961 (51.9%) нь НЭМГ-ын харьяа эмнэлэгт, 4605 (48.1%) нь нийслэлд үйл ажиллагаа явуулж буй

ЭМЯ-ны харьяа улс болон хувийн хэвшлийн эмнэлэгт амаржсан байна. Нийт амаржсан эхчүүдийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байна.


ХҮСНЭГТ 3. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 4 сард

Үзүүлэлт	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	2026 I-IV 2025 I-IV	
				эерүү	хувь
Амаржсан эхийн тоо	10 249	9 560	9 566	6	0.1
Гэрийн төрөлт	36	27	27	0	0.0
Хяналтгүй төрөлт	74	76	70	-6	-7.9
Амьд төрсөн хүүхэд	10 347	9 657	9 690	33	0.3
Эхийн эндэгдэл	2	3	2	-1	-33.3
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	131	151	142	-9	-6.0
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	12.7	15.6	14.7	-0.9	/

2026 оны эхний 4 сард 9690 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 33 (0.3%) хүүхдээр олон байна. Төрсөн нийт хүүхдийн

1904(19.6%) нь бусад аймгийн харьяат эхчүүдээс мэндэлжээ.


ЗУРАГ 1. АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, дүүргээр



Төрсөн нийт хүүхдийн 4929 (50.8%) нь хүү, 4761 (49.2%) нь охин байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 2 ихэр хүүхэд 153, 3 ихэр хүүхэд 3 байна.

Амьгүй төрөлтийн 34 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17 тохиолдлоор буурсан байна. Амьгүй төрөлт Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Багануур дүүрэгт хотын дунджаас өндөр байна.

ЗУРАГ 2. ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН (1000 амьд төрөлтөд ногдох)




Нийслэлд 2026 оны эхний 4 сард бүртгэгдсэн нялхсын эндэгдлээс Баянзүрх дүүрэгт 26(18.3%) нь, Сонгинохайрхан дүүрэгт 22(15.5%) нь, Хан-Уул дүүрэгт 14(9.9%) нь, Сүхбаатар дүүрэгт 9(6.3%) нь, Баянгол дүүрэгт 6(4.2%) нь, Чингэлтэй дүүрэгт 7(4.9%) нь, Налайх дүүрэгт 5(3.5%), Багануур дүүрэгт 5(3.5%) нь бусад

аймгийн харьяат 48(33.8%), Багахангай дүүрэгт бүртгэгдээгүй байна.

Нийслэлд 2026 оны эхний 4 сард 8352 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 1205 (16.9%) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 3. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварт өвчний төрлөөр нь авч үзвэл амьсгалын замын цочмог халдварт өвчин 2039(41.7%), бэлгийн

замаар дамжих халдварт өвчин 1263(25.8%), гэдэсний халдварт өвчин 274(5.6%), бусад халдварт өвчин 1312 (26.8%) байна.

ХҮСНЭГТ 4. НИЙСЛЭЛД БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 4 сард

Төрөл	Хэмжих нэгж	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	2026 I-IV 2025 I-IV	
					зөрүү	хувь
НИЙТ	тоо	5 972	7 147	8 352	1 205	16.9
	10000 хүнд	36.9	44.2	49.8	5.6	
Үүнээс:						
Вируст гепатит	тоо	42	64	40	- 24	-37.5
	10000 хүнд	0.26	0.4	0.24	-0.16	
Цусан суулга	тоо	366	250	233	- 17	-6.8
	10000 хүнд	2.26	1.51	1.4	-0.11	
Салхин цэцэг	тоо	2 187	2 230	1 488	- 742	-33.3
	10000 хүнд	13.51	13.4	8.9	-4.50	
Гахай хавдар	тоо	136	16	30	14	87.5
	10000 хүнд	0.84	0.1	0.18	0.08	
Сальмонеллэз	тоо	73	77	144	67	87.0
	10000 хүнд	0.5	0.5	0.7	0.2	
Улаан эсэргэнэ	тоо	236	132	203	71	53.8
	10000 хүнд	1.47	0.8	1.2	0.4	
Хоолны хордлого	тоо	20	406	93	-313	-77.1
	10000 хүнд	0.12	2.5	0.6	-1.9	
Ёлом	тоо	47	48	39	-9	-18.8
	10000 хүнд	0.29	0.3	0.2	-0.1	
Бруцеллэз	тоо	-	2	1	- 1	-50.0
	10000 хүнд	-	0.01	0.01	0.0	
Гар, хөл, амны өвчин	тоо	572	224	1 356	1 132	6.1*
	10000 хүнд	3.53	1.4	8.1	6.7	
Улаанбурхан	тоо	0	678	475	-203	-29.9
	10000 хүнд	0.0	4.1	2.8	-1.3	
Халдварт эритма	тоо	2	185	192	7	3.8
	10000 хүнд	0.01	1.1	1.1	0.0	
Тэмбүү	тоо	925	967	875	- 92	-9.5
	10000 хүнд	5.7	5.8	5.2	-0.6	
Гонококкт халдвар	тоо	446	590	455	- 135	-22.9
	10000 хүнд	2.8	3.6	2.7	-0.9	
Трихомониаз	тоо	289	594	394	- 200	-33.7
	10000 хүнд	1.8	3.6	2.4	-1.2	
Сүрьеэ	тоо	462	444	379	- 65	-14.6
	10000 хүнд	2.9	2.7	2.3	-0.4	
ДОХ	тоо	6	12	8	- 4	-33.3
	10000 хүнд	0	0.1	0.1	0.0	

* Дахин их

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



ГЭМТ ХЭРЭГ

Нийслэлд 13818 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 699 (5.3%) хэргээр өссөн байна.

2026 оны 4 дүгээр сард 13818 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 699 (5.3%) хэргээр, гэмт хэргийн илрүүлэлт 42.6 хувьтай байгаа нь 22.3 нэгж хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 2302 хүн гэмтэж осолдон, 240 хүн нас барж, төр ард иргэдэд 277.8 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 46.0 тэрбум (16.5%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

ЗУРАГ 4. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 42.5 хувийг залилан, 15.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 18.6 хувийг хулгайн, 3.7 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.8 хувийг

дээрмийн, 1.2 хувийг хүчин, 1.4 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 1.2 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 0.3 хувийг хүн амь, 14.1 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Төрөл	Гэмт хэргийн тоо			2026 I-IV / 2025 I-IV	
	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	Зөрүү	Хувь
НИЙТ	9 058	13 119	13 818	699	5.3
Хүний амь	40	32	42	10	31.3
Хүчин	120	161	171	10	6.2
Дээрэм	174	265	248	-17	-6.4
Хулгай	1 820	3 106	2 565	-541	-17.4
Залилан	3 102	4 552	5 874	1 322	29.0
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	1 831	2 090	2 088	-2	-0.1
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	303	574	515	-59	-10.3
Бусдыг амиа хорлоход хүргэх	158	236	191	-45	-19.1
Бусдын хөрөнгө ашиглах	195	220	172	-48	-21.8
Бусад гэмт хэрэг	1 315	1 883	1 952	69	3.7

2026 оны эхний 4 сард 3917 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 450 (13.0%) хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			2026 I-IV 2025 I-IV	
	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	Зөрүү	Хувь
НИЙТ	9 058	13 119	13 818	699	5.3
Багануур	114	189	137	- 52	-27.5
Багахангай	10	9	13	4	44.4
Баянгол	1 780	2 277	2 385	108	4.7
Баянзүрх	1 922	3 486	3 445	- 41	-1.2
Налайх	135	111	110	-1	-0.9
Сонгинохайрхан	1 445	1 770	1 953	183	10.3
Сүхбаатар	1 423	1 951	2 053	102	5.2
Хан-Уул	1 191	2 047	2 154	107	5.2
Чингэлтэй	1 038	1 279	1 568	289	22.6

2026 оны эхний 4 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 12334 (89.3%) нь хөнгөн хэрэг, 1484 (10.7%) нь хүнд хэрэг байна.

ХҮСНЭГТ 7. ГЭМТ ХЭРЭГ БҮРТГЭГДЭХ ҮЕД СЭЖИГТНЭЭР ТООЦВОЛ ЗОХИХ ЭТГЭЭД НЬ ТОГТООГДООГҮЙ ХЭРГИЙН ТОО, 2026 оны эхний 4 сард

Дүүрэг	Хэрэг бүртгэлтийн хэргийн тоо	Үүнээс: Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
НИЙТ	13 236	5 640	42.6
Багануур	121	55	45.5
Багахангай	9	9	100.0
Баянгол	2 314	1 130	48.8
Баянзүрх	3 297	1 364	41.4
Налайх	108	51	47.2
Сонгинохайрхан	1 834	794	43.3
Сүхбаатар	1 989	790	39.7
Хан-Уул	2 070	831	40.1
Чингэлтэй	1 494	616	41.2

ЗУРАГ 5. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ХУВЬ, 2026 оны эхний 4 сарын байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2026 оны эхний 4 сард 6720 болж, өмнөх оны мөн үеэс 3656 (2.2 дахин их) хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 955 (14.2%) нь согтуугаар, 1104 (16.4%) нь бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг байна. Сэжигтэн, яллагдагчийн 393 (5.8%) нь хүүхэд, 1447 (21.5%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Хулгайн гэмт хэргийн тоо, бүгд			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV
НИЙТ	1 820	3 106	2 565	1 794	1 731	1 918
Багануур	14	29	19	14	17	14
Багахангай	1	-	2	-	-	2
Баянгол	374	547	389	367	310	301
Баянзүрх	358	929	663	354	526	525
Налайх	18	13	14	17	10	13
Сонгинохайрхан	327	424	371	325	248	257
Сүхбаатар	341	427	386	337	230	279
Хан-Уул	176	433	435	170	232	337
Чингэлтэй	211	304	286	210	158	190

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16. түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус

хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ


Нийслэлийн төсвийн нийт орлого 1243.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 237.2 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Нийслэлийн төсвийн нийт орлого 2026 оны эхний 4 сарын байдлаар 1243.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 237.2 (16.0%) тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 1118.8 (90.0%) тэрбум төгрөгийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 124.4 (10.0%) тэрбум төгрөгийг татварын бус орлого тус тус эзэлж байна. 2026 оны эхний 4 сарын байдлаар татварын орлого 1118.8 тэрбум төгрөг

болж, төлөвлөснөөс 211.7 (15.9%) тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 124.4 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 25.5 (17.0%) тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

Орлогын албан татвар 201.5 (17.7%) тэрбум төгрөг, хөрөнгийн албан татвар 3.8 (3.7%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр, хураамж 6.4 (7.2%) тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн байна.

ЗУРАГ 6. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА



ХҮСНЭГТ 9.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны эхний 4 сард, дүүргээр


Дүүрэг	Төсвийн орлого			Үүнээс					
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Татварын орлого			Татварын бус орлого		
				Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
сая төгрөг									
НИЙТ	1 480 454.8	1 243 281.0	- 16.0	1 330 503.6	1 118 841.1	- 15.9	149 951.2	124 439.9	- 17.0
Багануур	9 691.0	8 935.1	- 7.8	8 065.7	7 101.8	- 12.0	1 625.3	1 833.3	12.8
Багахангай	925.4	1 097.9	18.6	732.8	859.9	17.4	192.6	238.0	23.6
Баянгол	130 153.0	108 554.1	- 16.6	128 408.2	104 486.0	- 18.6	1 744.8	4 068.1	2.3**
Баянзүрх	148 617.1	120 849.1	- 18.7	147 513.7	116 547.4	- 21.0	1 103.4	4 301.7	3.9**
Налайх	13 112.0	7 821.0	-40.4	11 630.8	7 026.6	-39.6	1 481.2	794.4	-46.4
Сонгинохайрхан	68 482.2	54 814.9	-20.0	67 512.7	52 858.3	-21.7	969.5	1 956.6	2.0**
Сүхбаатар	251 937.1	217 648.6	-13.6	250 404.9	211 298.1	-15.6	1 532.2	6 350.5	4.1**
Хан-Уул	229 098.1	193 110.9	-15.7	226 908.6	186 867.6	-17.6	2 189.5	6 243.3	2.8**
Чингэлтэй	131 976.9	102 923.6	-22.0	129 941.8	98 724.0	-24.0	2 035.1	4 199.6	2.1**
Хотын шууд	496 462.0	427 525.8	-13.9	359 384.4	333 071.4	-7.3	137 077.6	94 454.4	-31.1

ХҮСНЭГТ 10.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны эхний 4 сард

Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Өөрчлөлт	
	сая төгрөг		Дүн	Хувь
НИЙТ	1 480 454.8	1 243 281.0	-237 173.8	- 16.0
Татварын орлого	1 330 503.6	1 118 841.1	-211 662.5	- 15.9
Орлогын албан татвар	1140 535.1	939 061.0	-201 474.1	- 17.7
Хувь хүний орлогын албан татвар	857 392.2	692 048.8	-165 343.4	- 19.3
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	643 933.7	473 029.7	-170 904.0	-26.5
Үйл ажиллагааны орлогын	35 517.8	30 371.1	-5 146.7	-14.5
Хөрөнгийн орлого	64 590.7	73 872.0	9 281.3	14.4
Хөрөнгө борлуулсны орлогын	31 868.0	33 174.5	1 306.5	4.1
Шууд бус орлого	81 482.0	81 601.5	119.5	0.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-62 999.9	-56 907.1	6 092.8	- 9.7
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	346 142.8	303 919.3	-42 223.5	- 12.2
Хөрөнгийн албан татвар	101 774.6	97 969.7	-3 804.9	- 3.7
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	42 859.1	37 948.2	-4 910.9	- 11.5
Бууны албан татвар	152.6	181.2	28.6	18.7
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	58 708.4	59 793.5	1 085.1	1.8
Малд ногдуулах албан татвар	54.5	46.8	- 7.7	- 14.1
Бусад татвар, төлбөр, хураамж	88 193.9	81 810.4	-6 383.5	- 7.2
Бусад нийтлэг төлбөр, хураамж	36 864.7	27 688.1	-9 176.6	-24.9
Газрын төлбөр	36 181.9	40 833.5	4 651.6	12.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр	2 205.2	2 034.0	- 171.2	- 7.8
Бусад татвар	12 942.1	11 254.8	-1 687.3	- 13.0
Татварын бус орлого	149 951.2	124 439.9	-25 511.3	- 17.0
Нийтлэг татварын бус орлого	144 451.2	124 439.9	-20 011.3	- 13.9
Хувьцааны ногдол ашиг	0.0	90.0	90.0	-
Төсөвт байгууллагын өөрийн орлого	12 084.9	18 339.5	6 254.6	51.8
Торгуулийн орлого	72 991.8	57 167.1	-15 824.7	-21.7
Түрээсийн орлого	740.0	579.2	- 160.8	-21.7
Хүүгийн орлого	1 666.7	-	-1 666.7	1
Бусад орлого	56 967.8	48 264.1	-8 703.7	- 15.3
Өмч хувьчлал	5 500.0	-	-5 500.0	1

ЗУРАГ 7. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО




ХҮСНЭГТ 11. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2026 оны эхний 4 сард

Үзүүлэлт	Зарлага		Өөрчлөлт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	сая төгрөг			
НИЙТ	1 955 112.0	1 606 225.1	- 348 886.9	- 17.8
Багануур	10 931.3	10 440.8	- 490.5	- 4.5
Багахангай	4 662.8	4 405.7	- 257.1	- 5.5
Баянгол	120 431.1	99 372.4	-21 058.7	- 17.5
Баянзүрх	104 252.1	63 173.4	-41 078.7	- 39.4
Налайх	17 050.3	13 442.0	-3 608.3	- 21.2
Сонгинохайрхан	60 700.8	53 327.4	-7 373.4	- 12.1
Сүхбаатар	248 412.3	184 896.8	-63 515.5	- 25.6
Хан-Уул	196 180.3	110 213.1	-85 967.2	- 43.8
Чингэлтэй	128 924.3	86 515.5	-42 408.8	- 32.9
Хотын шууд	1 063 566.7	980 438.0	-83 128.7	- 7.8

2026 оны эхний 4 сарын байдлаар нийслэлийн төсвөөс нийслэл, дүүргийн байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 1606.2 (82.2%) тэрбум төгрөгийг санхүүжүүлжээ.

Өөрөөр хэлбэл нийслэл, дүүргийн байгууллагууд батлагдсан төсвийнхөө 348.9 (17.8%) тэрбум төгрөгийг зарцуулаагүй байна.

ЗУРАГ 8. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА



Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар өслөө.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2026 оны 4 дүгээр сард нийслэлийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар, өмнөх сараас 3.0 хувиар өссөн байна.

ЗУРАГ 9. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний үнийн индекс 2026 оны 4 дүгээр сарыг өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 21.1 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис бүлгийн үнэ 11.9 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 6.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 10.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний


бүлгийн үнэ 8.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний үнэ 6.8 хувь, боловсролын үйлчилгээний үнэ 13.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 9.5 хувь, даатгал санхүүгийн үйлчилгээний үнэ 23.6 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 11.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 12. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр


Бараа үйлчилгээний бүлгийн нэр	2025-IV	2026-IV	2026-IV	2026-IV
	2024-IV	2025-IV	2025-XII	2025-III
	Хувь			
Ерөнхий индекс	9.8	10.1	6.0	3.0
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	7.1	21.1	14.7	5.9
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	5.7	11.9	5.2	2.7
Хувцас, бөс бараа, гутал	10.7	6.1	0.9	0.1
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	25.8	1.3	-0.6	1.6
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	7.5	10.5	5.3	1.0
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	5.5	8.1	3.4	1.2
Тээвэр	5.8	2.7	5.9	4.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	-0.4	2.5	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	5.3	6.8	0.9	0.1
Боловсролын үйлчилгээ	20.4	13.6	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	14.8	9.5	7.3	2.4
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	6.1	23.6	23.6	23.6
Бусад бараа, үйлчилгээ	11.6	11.3	2.2	1.4

2026 оны 4 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 418 төрлийн бараа, үйлчилгээний үнийг өмнөх сартай харьцуулахад 208 (49.8%) бараа үйлчилгээний үнэ өсөж, 44 (10.5%) бараа үйлчилгээний үнэ буурч, 166 (39.7%) бараа үйлчилгээний үнэ тогтвортой байв.


ЗУРАГ 10. НЭГ ШИРХЭГ ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 4 дүгээр сард



ЗУРАГ 11. НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 4 дүгээр сард




ЗУРАГ 12. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 4 дүгээр сард



ЗУРАГ 13.

НЭГ ЛИТР ТАРАГ, СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 4 дүгээр сард



ХҮСНЭГТ 13.

НЭГ КИЛОГРАММ МАХНЫ ЖИЖИГЛЭН ХУДАЛДАХ ДОЛОО ХОНОГИЙН ДУНДАЖ ҮНЭ, сараар

Үхрийн ястай мах												
Он	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
төгрөг												
2021	11 614	12 606	12 666	13 853	13 956	14 768	14 793	13 700	13 420	13 277	13 342	13 493
2022	14 059	13 999	14 255	14 532	15 144	15 387	15 119	14 236	13 730	13 562	13 226	13 395
2023	13 610	14 416	15 072	16 747	18 476	20 100	19 040	16 436	16 277	15 688	15 542	15 842
2024	16 436	17 149	17 624	18 126	19 531	18 895	18 533	17 735	18 137	17 864	17 783	18 261
2025	19 073	19 637	19 932	20 064	20 280	21 285	21 524	20 793	20 755	20 810	20 689	21 343
2026	23 570	24 581	26 178	28 911								


Хонины ястай мах												
Он	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
төгрөг												
2021	9 034	10 459	10 692	12 318	12 389	12 696	12 440	11 380	10 974	11 006	10 773	10 846
2022	11 530	11 939	12 585	12 620	12 705	12 803	12 358	11 526	11 022	10 238	9 806	9 918
2023	10 545	11 721	12 820	14 062	15 369	16 597	15 288	13 237	12 702	12 006	11 834	12 078
2024	12 923	13 776	13 917	14 628	16 054	16 355	15 294	14 745	14 510	14 245	14 088	14 697
2025	15 560	16 495	17 177	17 458	17 270	17 088	17 005	16 830	16 696	16 675	16 553	16 909
2026	18 179	19 181	21 214	24 968								

2026 оны 4 дүгээр сард хүнсний зах, супермаркет, бөөний төвүүдэд жижиглэн худалдаалагдаж буй үхрийн ястай махны үнэ


өмнөх сартай харьцуулахад 10.4 хувиар, хонины ястай махны үнэ 17.6 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 14.

НЭГ КГ ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, 4 дүгээр сард



ЗУРАГ 15. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, өөрчлөлт орсон өдрөөр




ХҮСНЭГТ 14. ТҮЛШНИЙ ҮНЭ, байршлаар

Байршил	2024.IV.29			2025.IV.28			2026.IV.27		
	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайжруулсан түлш 25 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайжруулсан түлш 25 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Хагас коксон шахмал түлш 25 кг
	Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод	
	төгрөг								
Хүчит шонхор зах	7 500	7 000	3 750	7 500	7 000	3 750	8 500	8 500	5 000
Сүхбаатар	7 500	7 000	3 750	7 500	7 000	3 750	9 000	9 000	5 000
Цайз зах	8 500	7 500	3 750	8 000	8 000	3 750	8 000	8 000	5 000
Хангай зах	7 000	7 000	3 750	7 000	7 000	3 750	8 000	8 000	5 000
Дундаж үнэ	7 625	7 125	3 750	7 500	7 250	3 750	8 365	8 365	5 000

ХҮСНЭГТ 15. ШАТАХУУНЫ ҮНЭ, төрлөөр

ШТС	2025.IV.28					2026.IV.27				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
	төгрөг									
Тэс	-	-	2 390	3 140	-	-	-	2 590	4 340	-
Петровис	3 710	2 370	2 390	3 140	-	4 010	2 370	2 590	4 340	-
Сод монгол	3 710	2 315	2 390	3 140	-	4 010	2 315	2 590	4 390	-
Шунхлай	3 710	2 350	2 390	3 140	-	4 010	2 350	2 590	4 320	-
Юнигаз	-	-	-	-	1 950	-	-	-	-	1 950
Дундаж үнэ	3 910	2 345	2 390	3 140	1 950	4 010	2 345	2 590	4 347	1 950

ЗУРАГ 16. АМ.ДОЛЛАРЫН ХАНШИЙН САРЫН ДУНДАЖ ХӨДӨЛГӨӨН²



² Эх үүсвэр: Монголбанкны статистикийн мэдээлэл

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс:

Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:

Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ):

Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t – Тайлант үе

0 – суурь үе

P_t^i – i барааны тайлант үеийн үнэ

P_0^i – i барааны тайлант үеийн үнэ

q_0^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 3 жилд нэг удаа шинэчилдэг.

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 418 бараа, үйлчилгээ (аймагт 333 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2023 оны үр дүнгээр жинг тооцон, 2023 оны дундаж үнийн суурьтайгаар 2025 оны 2 дугаар сараас эхлэн тархааж байна.

ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.



МАЛ АЖ АХУЙ

Нийслэлийн хэмжээнд 2026 оны эхний 4 сарын байдлаар 2838 толгой том мал хорогдсон байна.

2026 оны эхний 4 сарын байдлаар 2838 толгой том мал зүй бусаар хорогдож, том малын зүй бус хорогдлын 1181 (41.6%) нь хээлтэгч мал

байна. Хорогдсон нийт малын 21.8 хувийг адуу, 39.0 хувийг үхэр, 15.9 хувийг хонь, 23.3 хувийг ямаа эзэлжээ.


ХҮСНЭГТ 16.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 4 САРЫН БАЙДЛААР, ДҮҮРГЭЭР

Дүүрэг	2025 I-IV		2026 I-IV		Өөрчлөлт	
	Хорогдсон мал	Хээлтэгч	Хорогдсон мал	Хээлтэгч	Дүн	хувь
	толгой					
Бүгд	449	107	1 872	805	1 423	4.2**
Багануур	78	7	251	94	173	3.2**
Багахангай	12	0	184	21	172	15.3**
Баянзүрх	89	26	383	175	294	4.3**
Налайх	79	32	388	139	309	4.9**
Сонгинохайрхан	97	32	415	344	318	4.3**
Хан-Уул	94	10	251	32	157	2.7**

ЗУРАГ 17.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН МЭДЭЭ, САРААР



Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол:

Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй) зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Бэлэн хээлтэгч:

Малын төрөл бүр дэх нас гүйцсэн эм малыг хамруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь:

Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.


МАЛ ТӨЛЛӨЛТ, БОЙЖИЛТ:

Нийслэлийн хэмжээнд төл бойжилт 98.3 хувьтай байна.

Нийслэлийн хэмжээнд 2025 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 200719 толгой хээлтэгч малын 41341 (20.6%) нь 2026 оны

эхний 4 сарын байдлаар төллөсөн байна. Нийт 41341 төл гарсны 721 төл мал хорогдож, 40620 төл бойжиж, төл бойжилт 98.3 хувьтай байна.

ЗУРАГ 18. БОЙЖУУЛСАН ТӨЛИЙН ТОО, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Мал төллөлтийн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төллөсөн хээлтэгч 1394 (3.3%) толгойгоор, бойжсон төл 1519 (3.6%) толгойгоор

тус тус буурсан байна. Бойжуулсан нийт төлийн 4.8 хувийг унага, 29.2 хувийг тугал, 39.2 хувийг хурга, 26.8 хувийг ишиг эзэлжээ.

ХҮСНЭГТ 17. МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Эх малын төрөл	Оны эхний хээлтэгч		Хорогдсон хээлтэгч		Төллөсөн хээлтэгч	
	2025	2026	2025 I-IV	2026 I-IV	2025 I-IV	2026 I-IV
	толгой					
Бүгд	206 465	200 719	205	1 181	42 735	41 341
Гүү	35 901	39 358	45	218	3 010	2 002
Үнээ	46 801	49 231	65	561	10 726	12 091
Ингэ	32	27	-	-	-	-
Эм хонь	71 300	64 836	44	188	17 122	16 171
Эм ямаа	52 431	47 267	51	214	11 877	11 077

Эм хонины 2022 толгой буюу 3.1 хувь, эм ямааны 916 толгой буюу 1.9 хувь, үнээний 5117 толгой буюу 10.4 хувь, гүүний 163 толгой буюу 0.4 хувь нь тус тус төллөсөн байна.

ХҮСНЭГТ 18. ТӨЛ БОЙЖИЛТ, дүүргээр, эхний 4 сарын байдлаар

Дүүрэг	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Төл Бойжилт
	толгой				
Дүн	41 341	41 341	721	40 620	98.3
Багануур	17 438	17 438	148	17 290	99.2
Багахангай	6 715	6 715	156	6 559	97.7
Баянзүрх	3 389	3 389	216	3 173	93.6
Налайх	2 710	2 710	27	2 683	99.0
Сонгинохайрхан	5 636	5 636	92	5 544	98.4
Хан-Уул	5 453	5 453	82	5 371	98.5

ХҮСНЭГТ 19.

ТӨЛ БОЙЖИЛТ, малын төрлөөр, эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2024	2025	2026	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
	толгой							
Гарсан төл	38 968	42 735	41 341	-	2 002	12 091	16 171	11 077
Бойжсон төл	37 230	42 139	40 620	-	1 937	11 849	15 932	10 902
Хорогдсон төл	1 738	596	721	-	65	242	239	175
Бойжилтын хувь	95.5	98.6	98.3	-	96.8	98.0	98.5	98.4

Ойлголт, тодорхойлолт:

Төллөлтийн хувь:

Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулж тооцно.

Төл бойжилтын хувь:

Бойжуулсан төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж тооцно.



АЖ ҮЙЛДВЭР

Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 76.0 хувиар өслөө

Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 12.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.4 (76.0%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд: уул уурхайн олборлолт

5.2 (2.2 дахин) их наяд төгрөг, боловсруулах үйлдвэрлэл 18.7 (6.8%) тэрбум төгрөг, цахилгаан, хий, уур, агааржуулалт 55.2 (6.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 20.

АЖ ҮЙЛДВЭРИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2025		2026*		Өөрчлөлт	
		IV	I-IV	IV	I-IV	Дүн	Хувь
Уул уурхай, олборлох аж үйлдвэр							
Чулуун нүүрс	мян.т	1 142.8	3 974.5	2 019.3	6 853.0	2 878.44	72.4
Хүрэн нүүрс, бөөгнөрөөгүй	мян.т	350.0	1 930.0	374.7	2 015.1	85.09	4.4
Газрын тос	мян.барр	353.6	1 447.5	293.9	1 192.7	-254.81	-17.6
Цэвэршүүлээгүй алт	кг	674.2	2 027.9	574.2	1 824.6	-203.35	-10.0
Хайлуур жонш	мян.т	0.2	0.8	11.4	23.4	22.64	30.5**
Мөнгөний баяжмал	т	2 665.6	5 937.5	951.4	1 814.1	-4 123.39	-69.4
Боловсруулах үйлдвэр							
Малын мах	т	922.1	10 346.1	1 006.7	3 566.4	-6 779.7	-65.5
Хиам	т	777.8	3 222.7	889.3	3 865.3	642.6	19.9
Боловсруулсан шингэн сүү	мян.л	4 920.8	19 373.2	5 733.4	21 124.7	1 751.5	9.0
Гурил	мян.т	5.9	41.3	11.3	33.9	-7.4	-17.9
Талх	т	2 453.3	9 209.2	2 380.1	8 559.4	-649.8	-7.1
Нарийн боов	т	1 993.7	6 582.1	2 227.2	7 564.5	982.4	14.9
Гоймон	т	634.7	1 970.8	218.5	865.4	-1 105.4	-56.1
Цэвэр спирт	мян.л	565.7	2 762.0	500.2	2 095.1	-666.9	-24.1
Цагаан архи	мян.л	1 356.1	6 884.9	1 060.7	5 681.3	-1 203.6	-17.5
Ус, ундаа, жүүс	сая.л	37.7	128.0	29.0	106.2	-21.8	-17.0
Янжуур тамхи	мян.блок	310.3	827.1	15.1	445.8	-381.3	-46.1
Сүлжмэл эдлэл-ноолуур	мян.ш	11.2	96.1	18.0	107.0	11.0	11.4
Самнасан ноолуур	т	55.3	151.1	52.1	187.1	36.0	23.9
Угаасан ноолуур	т	-	1.8	-	-	-1.8	1
Нүүрсэн шахмал түлш	мян.т	43.7	213.4	-	-	-213.4	1
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж							
Цахилгаан эрчим хүч	сая.квт.цаг	637.5	2 943.6	750.6	3 396.0	452.3	11.7
Дулааны эрчим хүч	мян.гкал	872.7	5 527.6	964.5	5 818.2	290.6	7.0
Усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон орчныг дахин сэргээх үйл ажиллагаа							
Төвлөрсөн сүлжээгээр цэвэр, бохир ус дамжуулах, түгээх үйлчилгээ (уур, халуун уснаас бусад)	мян.м3	4 407.4	17 546.8	4 916.7	19 119.9	1 573.0	3.5

ХҮСНЭГТ 21.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

Салбар	Нийт үйлдвэрлэл			2026* I-IV
	2024 I-IV	2025 I-IV	2026* I-IV	2025 I-IV
	сая төгрөг			Хувь
БҮГД	5 087 645.7	7 109 900.9	12 516 734.6	76.0
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	2 479 781.9	4 402 066.8	9 638 246.4	2.2**
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	507 542.4	690 386.8	918 042.1	33.0
Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт	393 735.7	333 828.6	294 693.3	- 11.7
Металлын хүдэр олборлолт	1 559 693.9	3 356 925.7	8 379 022.3	2.5**
Бусад ашигт малтмал олборлолт	8 846.0	5 781.3	24 884.5	4.3**
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	9 963.9	15 144.4	21 604.2	42.7
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	1 849 719.4	1 743 078.4	1 861 766.9	6.8
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	967 872.9	1 031 944.3	1 183 375.1	14.7
Мах боловсруулах, консервлох	182 703.3	195 763.4	186 096.8	- 4.9
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	15 425.0	24 605.5	22 872.7	- 7.0
Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	150 909.8	161 055.0	229 842.4	42.7
Үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл	94 623.0	79 618.9	90 102.8	13.2
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	153 435.1	183 086.4	208 992.9	14.1
Малын тэжээл үйлдвэрлэл	4 810.2	1 828.5	1 659.5	- 9.2
